



ХОВД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 11/02

Ховд

“Нээлттэй Ховд” хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.16, 20.3, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Монгол Улсын засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгүүд, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 11 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Нээлттэй Ховд” хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахтай холбогдох төсөв, төлөвлөгөөг аймаг, орон нутгийн жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийн үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Э.Болормаа)-д үүрэг болгосугай.

3.Нээлттэй Ховд хөтөлбөр батлагдсантай холбогдуулан сумын хэмжээнд арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ИТХ-аар батлуулан үр дүнтэй хэрэгжүүлэхийг сумын ИТХ-ын дарга наарт зөвлөж, Засаг дарга наарт үүрэг болгосугай.

4.Хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.



ХУРЛЫН ДАРГА Г.ПУРЭВГАНДИ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 1102 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт



“НЭЭЛТТЭЙ ХОВД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-аар батлуулан хэрэгжилтийг ханганд ажиллаж байна. Тус бодлогын баримт бичигт боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөөгийн тэнцвэрт хөгжил, ногоон хөгжил, төрийн бүтээмж зэрэг 6 багц асуудал туссан байна.

Хот хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг хангах зорилтын хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарсан.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгийн онцлогийг тусгасан бие даасан хөтөлбөр батлан, хэрэгжүүлэхээр нэмэлт оруулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд манай аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлс, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “НЭЭЛТТЭЙ ХОВД” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын бичиг баримт, хөтөлбөр, үйл ажиллагаа, судалгаанд үндэслэн боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

"Нээлттэй Ховд" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бус нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.2. Аймаг, орон нутагт шилжин ирж ажиллаж, амьдрах үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсэж болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож, мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээх;

2.3. Хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсон байх;

2.4. Иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих:

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Аймгаа бие даасан эдийн засагтай болгох суурь нөхцөлийг бүрдүүлж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэн, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бий болгох замаар аймгийн хүн амыг нэмэгдүүлэх, хот хөдөөгийн тэнцвэрт байдлыг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт

"Нээлттэй Ховд" хөтөлбөрийг ажил хэрэг болгоходоо дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1. Бизнесийн таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалт татах замаар бус нутгийн болон орон нутгийн томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэх,

4.2. Төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,

4.3. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх,

4.4. "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлого"-ыг олон нийтэд сурталчилж, хамтын ажиллагааг өргөжүүлэх,

4.5. Хүний нөөцийн зохистой бодлого боловсруулан хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийг ажиллах хүчээр хангах боломжийг бүрдүүлж, мэргэжилтэй боловсон хүний хомсдолыг багасгахад дэмжлэг үзүүлэх,

Тав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа, арга хэмжээ

5.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

5.1.1. Иргэн, аж ахуйн нэгжүүдэд, эзэмших, өмчлөх, ашиглах чиглэлээр газрыг нээлттэй, шуурхай олгоно.

5.1.1.а Иргэнд 0,07 га газрыг сум, суурин газарт, өмчлөх буюу эзэмшүүлнэ.

5.1.1.б Үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын зориулалттай газрыг хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээдэд нээлттэй сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулна.

5.1.1.в Орлогод нийцсэн үнэ бүхий орон сууцны зориулалттай газрыг нээлттэй сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэн, нийтийн эдэлбэрт шилжүүлэх замаар төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.

5.1.2. Ундны цэвэр усны 2 дугаар эх үүсвэрийг барьж, ашиглалтад оруулна.

5.1.3. Дулааны станцын өргөтгөлийг барьж, ашиглалтад оруулна.

5.1.4. Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам, сүлжээ, ариутгах татуургын өргөтгөл, шинэчлэл хийнэ.

5.1.5. "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

5.1.6. Олон улсын 4С ангиллын нисэх буудлыг ашиглалтад оруулна.

5.1.7. Баруун бүсийн эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгоно.

5.1.8. Булган, Байтаг боомтын үйл ажиллагаа, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

5.1.9. Босоо тэнхлэгээр дамжин өнгөрөх олон улсын төмөр зам барих ажлыг эхлүүлнэ.

5.1.10. Сум, суурин газруудад орон сууц, үйлчилгээний барилга байгууламж бүхий шинэ суурьшлын бүс байгуулна.

5.1.11. Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг ашиглалтад оруулна.

5.1.12. Сэргээгдэх болон бусад эрчим хүчний эх үүсвэрүүдийг шинээр байгуулна.

- 5.1.13. Баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.
- 5.1.14. Олон улсын тээвэр, логистикийн төв байгуулна.
- 5.1.15. Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай зам барина.
- 5.1.16. Ховд-Завхан чиглэлийн 400 км хатуу хучилттай зам барина.
- 5.1.17. Аймгийн төвийг сумдтай хатуу хучилттай замаар бүрэн холбоно.
- 5.1.18. Баруун бүсийн санхүүгийн төв болно
- 5.1.19. Хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, цогцолбор агро парк бий болгоно.
- 5.1.20. Бүс нутгийн татварын хөнгөлөлттэй бодлогыг хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- 5.2.1. Төрийн байгууллагын зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлнэ.
- 5.2.2. МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийг түшиглэн “Шинжлэх ухаан, технологийн инновациын төв”-ийг байгуулна.
- 5.2.3. Баруун бүсийн барилга, цахилгаан болон ундны усны аюулгүй байдлын лаборатори байгуулна.
- 5.2.4. БОЭТ-ийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.
- 5.2.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай эмнэлэг, сургууль, цэцэрлэг байгуулахыг бодлогоор дэмжинэ.
- 5.2.6. Цаст-Алтай ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр нэвтрүүлнэ.

- 5.2.7. Баруун бүсийн “Дата центр” байгуулна.

- 5.2.8. Төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, шуурхай, ил тод, нээлттэй болгоно.

- 5.2.9. Иргэн бүрд гадаад хэлний боловсрол олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд:

- 5.3.1. Аймгийн онцлог, түүх, соёл, зан заншлыг агуулсан нутгийн брэнд бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд таниулах ажиллагааг эрчимжүүлнэ.

- 5.3.2. Зам дагасан үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний төвүүд байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

- 5.3.3. Дотоод болон гадаадын сүлжээ дэлгүүр, үйлчилгээний төвүүд байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

- 5.3.4. Аялал жуулчлалын эвент арга хэмжээг тогтмол зохион байгуулна.

5.3.5. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг орчмын бүст аялал жуулчлал хөгжүүлэхийг орон нутгийн зүгээс дэмжинэ.

5.3.6. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар, рашаан сувилал, байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газруудад аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдад нээлттэй сонгон шалгаруулалтаар ашиглуулна.

5.4. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

5.4.1. "My Khovd", "Invest Khovd", "Visit Khovd" нэгдсэн төвүүдийг байгуулж, иргэд, аж ахуйн нэгжийг мэдээллээр хангаж холбон зуучилна.

5.4.2. "Хөдөлмөрийн яармаг"-ийг улирал тутам тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

5.4.3. Баруун бүсийн хөрөнгө оруулалтын чуулга, "Invest Khovd" арга хэмжээг жил бүр зохион байгуулна.

5.4.4. Олон улсын эдийн засгийн форум, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.

5.4.5. Үйл ажиллагаагаа амжилттай эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын сайн туршлагыг дэлгэрүүлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчилна.

5.4.6. Баялаг бүтээгчдийн чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна.

5.4.7. Аймгаа сурталчлах хөтөч-гарын авлагатай болно.

5.5. Хөтөлбөрийн 5 дугаар зорилтын хүрээнд:

5.5.1. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хангах бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжүүлнэ.

5.5.2. МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, "Хөгжил" политехник коллежийн төгсөгчдийг орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.

5.5.3. Ховд аймагт нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнийг сургахад төр аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, тэтгэлэг олгоно.

5.5.4. Орон нутагт шилжин суурьших хүсэлтэй нарийн мэргэжлийн болон өндөр чадамжтай мэргэжлийн боловсон хүчнийг орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

5.5.5. Сум бүр орон нутагтаа шаардлагатай боловсон хүчнийг тогтвортой суурьшилтай ажиллахад нь нөлөөлөхүйц эдийн засгийн дэмжлэг үзүүлнэ.

5.5.6. Төрийн албан хаагчдын цалинг үе шаттайгаар 100 хувь хүртэл нэмэгдүүлнэ.

5.5.7. Сум орон нутагт ажиллаж буй төрийн захиргааны зарим албан тушаалыг төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд шилжүүлэх санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид ажлын хэсэг гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын Ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн Засаг даргын орлогч байна.

6.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь 15 хүртэлх гишүүнтэй байх бөгөөд хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн гэх зэрэг төлөөлөлтэй байна. Түүнчлэн Улаанбаатар хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлөөр оруулж болно.

6.3. Ажлын хэсэг нь аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөөг боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулна.

6.4. Ажлын хэсэг нь олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, жилийн эцсээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, үр дүнг аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

Долоо. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 3 үе шаттай хэрэгжүүлнэ.

7.1.Хөтөлбөрийн нэгдүгээр үе шатыг 2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

7.2. Хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг 2024-2028 онд,

7.3. Хөтөлбөрийн гуравдугаар шатыг үе 2028-2032 онд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

- 8.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
 - 8.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусlamжийн хөрөнгө;
 - 8.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусlamжийн хөрөнгө;
 - 8.1.4. Бусад.
- 8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.
- 8.3. My Khovd арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх Шинээр суурьшсан өрх, гэр бүлийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны төлбөрийг 1 жилийн хугацаанд 100% чөлөөлөх болон орон сууцны түрээсийн төлбөрийн асуудлыг аймгийн Засаг даргын баталсан журмын дагуу Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

Ес. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

9.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

9.1.1. Бизнесийн таатай орчин бүрдүүлж, хөрөнгө оруулалт татах замаар бус нутгийн болон орон нутгийн томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн, аймгийн төвийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.

9.1.2. Төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна.

9.1.3. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэн, иргэдийн амьжиргааны түвшин дээшилнэ.

9.1.4. Шинэ суурьшлын бус, сум орон нутаг, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, аймгаа бие даасан эдийн засагтай болгох суурь нөхцөлийг бүрдүүлэн, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бий болгох замаар аймгийн хүн амьг нэмэгдүүлж, хот хөдөөгийн тэнцвэрт байдлыг хангана.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хавсралтаар баталсан шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

9.3. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх түвшнийг үзүүлэлтийг тухайн хариуцсан байгууллага тооцож, ажлын хэсэгт жилийн бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ.

9.4. Ажлын хэсэг Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түшинг нэгтгэж, аймгийн ИТХ-д тайлагнана.

--оOо--

Аймийн Иргэдийн Төлөөлөгчийн
Хурлын 2023 оны 11/20 дугаар тогтолцын
хөвөрдүү зорилтуулалт

“НЭЭЛТТЭЙ ХОВД” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	“Нээлттэй Ховд” хөтөлбөрт тусгатсан арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2023-2032 он (саянгэр)	Суурь тувшин	Хэрэгжүүлэх байгууллага			
						2023-2024 он (15 сар)	2024-2028 он	2028-2032 он	Үндсэн Хамтрагч
“Нээлттэй Ховд” хөтөлбөрийн зорилго: Аймгаа бие даасан эдийн засагтай болгох суурь нөхцөлийг бурдуулж, эдийн засаг, нийтийн хөгжлийг эрчимжүүлэн, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрас таатай орчин бий болго замаар аймгийн хүн амьт намздуулэх, хот хөдөөгийн тэнцвэрт байдлыг хангах									
1	НЭГДҮГЭЭР ЗОРИЛТ: Бизнесийн таатай орчин бурдуулж, хөрөнгө оруулалт татах замаар бус нутгийн болон орон нутгийн томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх								
1.1	Иргэн, аж ахуйн нэжүүдэд, эзэмших, емчилөх, ашиглах чиглэлээр газрыг нээлттэй, шуурхай олгоно.	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2023-2032 он (саянгэр)	Суурь тувшин	Хүрэх тувшин, үр дүн			
1.1.a	Иргэнд 0,07 га газрыг сум, суурин газарт, емчлөх буюу эзэмшигүүнэ.	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2023-2032 он (саянгэр)	Суурь тувшин	Хүрэх тувшин, үр дүн			
1.1.6	Үйлдвэр, үйлчилгээ, хөдөө аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын зориулалттай газрыг хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээдэд нээлттэй сонгон шалгаруулалтаар эзэмшигүүлж, ашиглуулна.	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2023-2032 он (саянгэр)	Суурь тувшин	Хүрэх тувшин, үр дүн			
1.1.b	Орлогод нийцсэн үнэ бүхий орон суучны зориулалттай газрыг	Хэрэгжих хугацаа	Хөрөнгийн эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2023-2032 он (саянгэр)	Суурь тувшин	Хүрэх тувшин, үр дүн			

			Түвшнээр (32 га)		
1.2.	Нээлттэй сонгон шалгаруулалтаар эзэмшүүлэн, нийтийн эдэлбэрт шилжүүлэх замаар төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ	Ундны цэвэр усны 2 дугаар эх үүсвэрийг барьж, ашиглалтад оруулна.	Улсын төсөв 38,000.0	ТЭЗҮ ХИЙГДСЭН	50% Ашиглалтад орно
1.3.	Дулааны станцын өргөтгөлийг барьж, ашиглалтад оруулна.	Улсын төсөв 8,000.0	Ажил эхэлсэн	Ашиглалтад орно	-
1.4.	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ ариутгах татуурлын өргөтөл, шинэчлэл хийнэ.	Улсын төсөв 7400,0-	-	ТЭЗҮ	Ашиглалтад орно
1.5.	“Шинэ Ховд” үйлдвэр технологийн паркийг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	Улсын төсөв 19,123.0	Ажил эхэлсэн	80 %	Үйл ажиллагаа эрчимжинэ
1.6.	Олон улсын 4С ангилийн нисэх буудлыг ашиглалтад оруулна.	Улсын төсөв 43,000.0	ТЭЗҮ ХИЙГДСЭН	70 %	Ашиглалтад орно
1.7.	Баруун бусийн эдийн засгийн чөлөөт бусийг бий болгоно.	Улсын төсөв, бусад	-	Санал хүргүүлэх	-
1.8.	Булган, Байtag боомтын үйл ажиллагаа, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	Улсын төсөв, бусад	2022 оны суурь түвшин	ТЭЗҮ	70 %
1.9.	Босоо тэнхлэгээр дамжин өнгөрөх олон улсын төмөр зам барих ажлыг эхлүүлнэ.	Улсын төсөв, гадаадын зээл тусгамж	Судалгаа, шинжилгээний ажил хийдэнэ	Зураг, төсөв боловсруулна	МУ-ЫН Засийн газар
					Хөрөнгө оруулагчид

1.10.	Сүм, суурин газруудад орон сууц, Үйлчилгээний барилга байгууламж бүхий шинэ суурьшлын бус байгуулна.	2022-2032	Улсын болон орон нутгийн төсөв, бусад Улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	-	1 суманд	3 суманд	5 суманд	8 суманд	Аймаг, сумын ЗДТГ
1.11.	Эрдэнэбүрэнтгийн усан цахилгаан станцыг ашиглалтад оруулна.	2022-2032	Улсын гүйцэтгэгч шалгарч, ажил эхэлсэн	818,500.0	Ажлын гүйцэтгэгч шалгарч, ажил эхэлсэн	30 %	Бүрэн ашиглалтад орно.	Үйл ажиллагаа жигдэрнэ	Баруун бүс
1.12.	Сэргээгдэх болон бусад эрчим хүчиний эх үүсвэрүүдийг шинээр байгуулна.	2022-2032	Улсын төсөв	-	2	Судалгая, шинжилгээн ийн ажил хийнэ	2-оор нэмэгдүүлнэ	2-ооп нэмэгдүүлнэ	ЭХЯ Аймгийн ЗДТГ
1.13.	Баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.	2023-2032	Улсын болон орон нутгийн төсөв, бусад	-	2022 оны суурь түвшин	1 үйлдвэр нэмж ашиглалтад орсон байна	5 үйлдвэр нэмж ашиглалтад орсон байна	10 үйлдвэр нэмж ашиглалтад орсон байна	ЭХЯ Аймгийн ЗДТГ
1.14.	Олон улсын тээвэр, логистикийн төв байгуулна.	2023-2032	Улсын төсөв	-	Судалгая, шинжилгээний ажил хийдэнэ	Барьж ашиглалтад оруулна	Үйл ажиллагаа жигдэрсэн байна	Үйл ажиллагаа жигдэрсэн байна	ЭХЯ Аймгийн ЗДТГ, АТТ
1.15.	Ховд-Улаантом чиглэлийн 163 км хатуу хүчинтэй зам барина.	2022-2028	Улсын төсөв	155,135.0	ТЭЗҮ хийдсэн	Ажлыг эхлүүлнэ	Замыг барина	-	ЭХЯ Аймгийн ЗДТГ, АТТ
1.16.	Ховд-Завхан чиглэлийн 400 км хатуу хүчинтэй зам барина.	2023-2028	Улсын төсөв	-	Судалгая, шинжилгээний ажил хийдэнэ	ТЭЗҮ хийгдэнэ	Зам барина	ЭХЯ Аймгийн ЗДТГ, АТТ	
1.17.	Аймгийн төвийг сумдтай хатуу хүчинтэй замаар бүрэн холбоно	2023-2032	Улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалт	-	11 сум холбогдсон	12 сум	13 сум	14 сум	ЭХЯ Аймгийн ЗДТГ, АТТ

1.18.	Баруун бусийн санхүүгийн төв болно.	2023-2032	-	-	Арилжааны банкны салбарууд	Судалгааны ажил	Төв байгуулна	Санхүүгийн зохицуулах хороо Баруун бус	Аймгийн ЗДТГ
1.19.	Хөдөө аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, цогцолбор агро парк бий болгоно.	2023-2032	Улсын төсөв, бусад	-	Агро парк төслийн хэрэгжилт 10%	30 %	50 %	100 %	Аймгийн ЗДТГ
1.20.	Бус нутгийн татварын хөнгөлөлттэй бодлогыг хэрэгжүүлнэ.	2022-2032	-	-	2022 оны суурь тувшин	Шилжин ирэх ААН-ийн тоо ёснэ	Шилжин ирэх ААН-ийн тоо ёснэ	Шилжин ирэх ААН-ийн тоо ёснэ	Татварын хэлтэс
ХОЁРДУГААР ЗОРИЛТ: Төр хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлж, төрийн ултичилгээний чанар, хүртээмжийг сайжруулах									
2.1.	Төрийн байгууллагын зарим чиг үргийг ТББ-аар гүйцэтгүүлнэ.	2023-2032	-	-	2022 оны суурь тувшин (8)	5-аар нэмэгдүүлнэ	10-аар нэмэгдүүлнэ	10-аар нэмэгдүүлнэ	Аймгийн ЗДТГ
2.2.	МУИС-ийн Ховд дахь салбар сургуулийг түшиглэн "Шинжлэх ухаан, технологийн инновацийн төв"-ийг байгуулна.	2023-2032	Улсын төсөв	2,000.0	ТЭЗҮ	20 %	100 %	Үйл ажиллагааг өргөжүүлнэ	Аймгийн ЗДТГ, МУИС-ийн Ховд салбар
2.3.	Баруун бусийн барилга, цахилгаан болон үндны усны аюулгүй байдлын лаборатори байгуулна.	2023-2032	Улсын төсөв	300.0	ТЭЗҮ	20 %	100 %	Үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Аймгийн ЗДТГ
2.4.	БОЭТ-ийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ	2023-2032	Улсын төсөв, бусад	-	Өвчиний олон улсын эмнэл зүйн "Up To date" платформ хэрэглээнд нэвтрүүлж байна	50 %	70 %	100 %	ЭМЯ, БОЭТ
2.5.	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай эмнэлэг, сургууль, Цэцэрлэг байгуулахыг бодлогоор дэмжиж.	2023-2032	Хувийн хэвшил	-	Эрүүл мэндийн байгууллага-6, цэцэрлэг-14	Нэмэгдсэн байна	Нэмэгдсэн байна	Нэмэгдсэн байна	Аймгийн ЗДТГ

2.6.	Цаст-Алтай ерөнхий боловсролын сургуульд олон улсын хөтөлбөр нэвтрүүлнэ.	2023-2032	Төсөл хөтөлбөр, ОУБ	-	10 %	70 %	100 %	Үйл ажиллагааг өргөжүүлнэ	Бшуя, ОУБ	Аймгийн ЗДТГ, БШУГ
2.7.	Баруун бусийн "Дата центр" байгуулна.	2023-2032	Улс, орон нутгийн төсөв	-	2022 оны суурь тувшин	40 %	100 %	Үйл ажиллагаа тогтолжино	Үндэсний дата төв	Аймгийн ЗДТГ
2.8.	Төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, шуурхай, ил тод, нээлттэй болгоно.	2023-2032	Улсын болон орон нутгийн төсөв	-	440 үйлчилгээ	500	600	700	ЦХЯ	Аймаг, сумдын ЗДТГ, төрийн байгууллагууд
2.9.	Иргэн бурд гадаад хэлний боловсрол олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2023-2032	-	-	10 %	15 %	30 %	50 %	Бшуя	Аймаг, сумдын ЗДТГ, БШУГ
ГУРАВДУГААР ЗОРИЛТ: Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх										
3.1	Аймгийн онцлог, түүх, соёл, зан заншлыг агуулсан нутгийн брэнд бүтээдэхүүн, үйлчилгээ бий болгоход дэмжлэг үзүүлж, иргэд, олон нийтэд таниулах ажиллагааг эрчимжүүлнэ.	2023-2032	Орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	-	2022 оны суурь тувшин	3-аар нэмэгдүүлнэ	5-аар нэмэгдүүлнэ	5-аар нэмэгдүүлнэ	Аймаг, сумдын ЗДТГ	Аж ахуйн нэгж, байгууллага
3.2.	Зам дагасан үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний төвүүд байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2023-2032	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад	-	2	3	5	8	Байгууллага, хөрөнгө оруулагчид	ААН
3.3.	Дотоод болон гадаадын сүлжээ дэлгүүр, үйлчилгээний төвүүд байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2023-2032	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад	-	2022 оны суурь тувшин	1-эр нэмэгдүүлнэ	3-аар нэмэгдүүлнэ	3-аар нэмэгдүүлнэ	Байгууллага, хөрөнгө оруулагчид	АЙМАГ, СУМДЫН ЗДТГ

3.4.	Аялал жуулчлалын эвент арга хэмжээг тогтмол зохион байгууна.	2023-2032	Орон нутгийн болон бусад	2	3	5	7	Аймаг, сумдын ЗДТГ	БОАЖГ, СУГ
3.5.	Улсын тусгай хамгаалалт-тай газар нутаг орчмын бүст аялал жуулчлал хөгжлийг орон нутгийн зүгээс дэмжинэ.	2023-2032	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад	8	9	11	13	ААН Байгууллага, хөрөнгө оруулагчид	Аймгийн ЗДТГ
3.6.	Орон нутгийн тусгай хамгаалалттай газар, рашидан сувилал, байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газруудад аялал жуулчлалын зориулалт таар Үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчад нээлттэй сонгон шалгаруулалтгаар ашиглувандаа.	2023-2032	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, бусад	6	8	11	15	Аймаг, сумдын ЗДТГ	ДАН байгуулла га, хөрөнгө оруулагчид
4.	ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛТ: "Хот, хөдөөгийн сэргээлийн бодлого"-ыг олон нийтэд сурталчилж, хамтын ажиллагааг өргөжүүлэх								
4.1.	"My Khovd", "Invest Khovd", "Visit Khovd" нэгдсан төвүүдийг байгуулж, иргэд, аж ахуйн нэгжийг мэдээлэлээр хангаж холбон зуучилна.	2023-2032	Орон нутгийн төсөв, бусад	Төвүүдийн Үйл ажиллагаа эхэлсэн	Үйл ажиллагаа жигдэрнэ	Үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Аймгийн ЗДТГ	ОНӨҮГ	
4.2.	"Хөдөлмөрийн яармаг"-ийг улирал тутам тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгууна.	2023-2032	Орон нутгийн төсөв, бусад	2022 оны сурь түвшин	Улирал тутам	Улирал тутам	Аймгийн ЗДТГ, төрийн Байгууллага, бусад	Хувийн хэвшлийн болон бусад	
4.3.	Баруун бүсийн хөрөнгө оруулатын чуулга, "Invest Khovd" арга	2023-2032	Орон нутгийн болон	2022 оны сурь түвшин	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Аймгийн ЗДТГ, бусад	Хувийн хэвшлийн болон бусад	

	хэмжээг жил бүр зохион байгууна.		бусад ХО-чид					
4.4.	Олон улсын эдийн засийн форум, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууна.	2022-2032	Орон нутгийн төсөв, гадаад, доогодын төсөл, хөтөлбөр	-	2022 оны суурь түвшин	2 жилд 1 удаа	2 жилд 1 удаа	Аймгийн ЗДТГ, Их дээд сургууль, бусад
4.5.	Үйл ажиллагаагаа амжилттай эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын сайн туршилтэй дэлгэрүүлж, олон нийтэд түгээн дэлгэрүүлж сургалгичтина.	2022-2032	Орон нутгийн төсөв, бусад	-	2022 оны суурь түвшин	-	-	Аймаг, сумдын ЗДТГ
4.6.	Баялаг бүтээгчийн чуулга Уулзалтыг жил бүр зохион байгууна.	2022-2032	Орон нутгийн төсөв, бусад	-	2022 оны суурь түвшин	Жилд 1 удаа	Жилд 1 удаа	Хувийн хэвшлийн болон бусад
4.7.	Аймгаа сурталчлах хөтөч гарын авлагатай болно.	2022-2032	Орон нутгийн төсөв, бусад	-	Гарын авлагатай болно	-	-	Аймгийн ЗДТГ
5.	ТАВДУГААР ЗОРИЛТ: Хүний нөөцийн зохицой бодлого боловсруулан хэрэгжкуулж, төр, хувийн хэвшлийг ажиллах хувцар хангах боломжийг бүрдүүлж, мэргэжилтэй боловсон хүчиний хомсдыг багасгахад дэмжлэг үзүүлэх							Бусад
5.1.	Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтыг хангах бодлогын баримт бичиг боловсруулан хэрэгжкуулна.	2022-2032	-	-	Судалгага, шинжилээний ажил	Хөтөлбөрөө боловсруул ж, хэрэгжжүүлнэ	Хэрэгжилт эрчимжинэ	Аймгийн ЗДТГ
5.2.	МУИС-ийн Ховд дахь салбар сургууль, "Хөгжил" политехник коллежийн төгсгөгчийг орон нутагт тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	2022-2032	-	-	2022 оны суурь түвшин (60 %)	5 хувиар өснө	5 хувиар өснө	Төрийн байгууллагууд, сумдын ЗДТГ

5.3.	Ховд аймагт нэн шаардлагатай мэргэжлийн боловсон хүчинийг сургахад тэр аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлж, тэтэлэг олгоно.	2022-2032	Орон нутгийн болон бусад, төсөл, хөтөлбөр	-	79	Жилд 80-аас дээш тоогоор нэмэгдүүлэх	Жилд 80-аас дээш тоогоор нэмэгдүүлэх	Аймгийн ЗДТГ	Хувийн хэвшлийн болон бусад
5.4.	Орон нутагт ширгэж суурьших хүснэгтэй нарийн мэргэжлийн болон өндөр чадамжтай мэргэжлийн болговсон хүчиний орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ.	2022-2032	Орон нутгийн хөрөнгө оруулалт, бусад	-	2	-	6	Аймаг, сумдын ЗДТГ	Төрийн байгууллагууд, Хувийн хэвшлийн болон бусад
5.5.	Сум бур орон нутагтаа шаардлагатай боловсон хүчиний тогтвортой суурьшилтай ажиллахад нь нөлөөлөхүүц эдийн засгийн дэмжлэг үзүүлнэ.	2023-2032	Орон нутгийн төсөв, бусад	-	-	Үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ	Үзүүлсэн дэмжлэгийн хэмжээ	Аймаг, сумдын ЗДТГ	Төрийн байгууллагууд, Хувийн хэвшлийн болон бусад
5.6.	Төрийн албан хаагчдын цалинг үе шаттагаар 100 хувь хуртэл нэмэгдүүлнэ.	2022-2032	Орон нутгийн төсөв, бусад	-	2022 оны сурь түвшин /50 %/	60 %	80 %	100 %	Аймгийн ЗДТГ
5.7.	Сум орон нутагт ажиллаж буй төрийн захирагааны зарим албан тушаалыг төрийн үйлчилгээний албан тушаалын анги-лапад шилжүүлэх санал хургуулж, шийдвэрлүүлнэ.	2022-2032	-	-	Судалгаа, шинжилгээ хийж, санал боловсруулна	Санаалаа, хургуулж, шийдвэрлүүлнэ	Хэрэгжүүлэх Улнэ	Аймгийн ЗДТГ	Сумдын ЗДТГ

“НЭЭЛТТЭЙ ХОВД” ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Алсын хараа-2050,	Хүрэх түвшин	Мэдээлэл цуглуулах
---	-------------------	--------------	--------------------

	Шинэ сэргэлтийн бодлого	Шалгур Үзүүлэлт	Хэмжих Нэгж	Суурь Тувшин (2022 он)	2023-2024 ОН (15 сар)	2024-2028 ОН	2028-2032 ОН	Шалгур Үзүүлэлтийн тайлбар	Давтамж	Хариуцах байгууллаг а
“Нээлттэй Ховд” бодлогын баримт бичгийн зорилго: Аймгаа бие даасан эдийн засагтай болгох суурь нөхцөлийг бурдудж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлэн, иргэдийг орон нутагт ажиллаж, амьдрах таатай орчин бий болгох замаар аймгийн хүн амьт нэмэгдүүлэх, хот хөдөөгийн тэнцвэрт байдлыг хангах										
1.	Зорилт 1: Бизнесийн таатай орчин бурдудж, хөрөнгө оруулалт татах замаар бус нутгийн болон орон томоохон тесел, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	Бизнесийн орчны Үнэлгээ, амьжиргааны төо тувшин, хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	2022 оны суурь тувшин	-	-	-	-	Үйлдвэрлэл, худалдаа, барилга, ХАА, Үйлчилгээний бусад салбарт хэрэгжсэн төсөл хөтөлбөрийг авч Үзнэ	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ
1.1.	Арга хэмжээ: Иргэн, эж ахуйн нэгжүүдэд, эзэмших, өмчлөх, ашиглалтад чиглэлээр газрыг нээлттэй, шуурхай олгоно.	Иргэд, хөрөнгө оруулагчад олгосон газрын хэмжээ	Хувь болон га	2022 оны суурь тувшин	-	-	-	Иргэдийн хэдэн хувьд олгосон болон хөрөнгө оруулагчад олгосон газрын хэмжэээр тооцно	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ
1.2.	Арга хэмжээ: Учдны цэвэр усны 2 дугаар эх Уусвэрийг барьж, ашиглалтад оруулна.	Барилга байгууламжийн гүйцэтгэл	Хувь	ТЭЗҮ хийгдсэн	50%	Ашиглалт ад орно	-	Барьж байгуулан уйл ажиллагааг хэвийн эрхэлж буйгаар тооцно	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ
1.3.	Арга хэмжээ: Дулааны станцын өргөтгөлийг барьж, ашиглалтад байгууламжийн гүйцэтгэл	Гүйцэтгэлийн барьж	Ажил эхэлсэн хувь	Ашиглалтад орно	-	-	-	Барьж байгуулан уйл ажиллагааг хэвийн эрхэлж буйгаар тооцно	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ
1.4.	Арга хэмжээ: Гэр хорооллын цэвэр бохир усны шугам супжээ ариутгах татууртын шинэчлэл хийнэ.	Цэвэрлэх байгууламжийн нэмэгдсэн хүчин чадал	Хувь	-	ТЭЗҮ	Ашиглалтад орно	Үйл ажиллагаага тогтвржино	Гүйцэтгэлийн хувиар тооцно	Жилд нэг удаа	Аймгийн ЗДТГ

1.5.	Арга хэмжээ: "Шинэ Ховд" Үйлдвэр технологийн паркийг ашиглалтад оруулж, үйл эрчимжүүлнэ.	Баригдсан үйлдвэрүүд	Хувь	Ажил эхэлсэн	80 %	Ашиглалтад орно	Үйл ажиллагаа эрчимжин э	Барьж байгуулан үйл ажиллагаагаа жилд нэг тооцно	Аймгийн ЗДТГ
1.6.	Арга хэмжээ: Олон улсын 4С ангиллын нисэх буудлыг ашиглалтад оруулна.	Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлсэн байдал	Хувь	ТЭЗҮ хийгдсэн	70 %	Ашиглалтад орно	-	Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын ангилаатай болгох	Аймгийн ЗДТГ
1.7.	Арга хэмжээ: Баруун бусийн эдийн засгийн чөлөөт бүсийг бий болгоно.	Экспорт, импортын хэмжээ	Сая төгрөг	-	Санал хүргүүлэх	70 %	Чөлөөт бустэй болно	Иргэн, ААН-ийн экспорт, импортыг дэмжих замаар ЭЗ-ийн ёсөлт нэмэгдэх	Аймгийн ЗДТГ
1.8.	Арга хэмжээ: Булган, Байтай боомтын үйл ажиллагаа, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	Нүурс экспортлох, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадлын хэмжээ	Хувь	2022 оны сурь түвшин	ТЭЗҮ хийгдэнэ	50 %	100 %	Эргэлт сайжрах	Жилд нэг удаа
1.9.	Арга хэмжээ: Босоо тэнхлэгээр дамжин өнгөрөх олон улсын төмөр зам барих ажлыг эхлүүлнэ.	Ашиглалтад оруулах төмөр замны урт	КМ	-	Судалгаа, шинжилгээний ажил хийгдэнэ	Зураг, төсөв боловсруулна	Ажил эхэлнэ	-	Жилд нэг удаа
1.10.	Арга хэмжээ: Сум, суурин газруудад орон суүц, үйлчилгээний барилга байгууламж бүхий шинэ суурьшлын бүс байгуулна.	Орон сууцны тоо ба шинэ суурьшлын бус бүхий сум	ТОО	1 суманд	3 суманд	5 суманд	8 суманд	Шинэ суурьшлын бусийн бүтээн байгуулалтын төслийр баригдсан орон сууцны тоо	Аймгийн ЗДТГ

1.11.	Арга хэмжээ: Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг ашиглалтад оруулна.	Гүйцэтгэлийн хувь	Ажлын гүйцэтгэгч шалгарч, ажил эхэлсэн	Бүрэн ашиглалтад орно.	Үйл ажиллагаа жигдэрнэ	Шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлнэ	Жилд нэг удаа	Аймгийн зДТГ
1.12.	Арга хэмжээ: Сэргээгдэх болон бусад эрчим хүчиний эх үүсвэр шинээр байгуулна.	Шинээр барилсан сэргээдэх эрчим хүчиний эх үүсвэр	ТОО	2	Судалгаа, шинжилгээний ажил хийнэ	2-оор нэмэгдүүл нэ	2-оор нэмэгдүүл нэ	Шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын тоогор илэрхийлнэ
1.13.	Арга хэмжээ: Баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүдийг барьж байгуулна.	Барилсан үйлдвэр	Барилсан үйлдвэр	ТОО	2022 оны суурь түвшин	5 үйлдвэр нэмж ашиглалтад орсон байна	10 үйлдвэр нэмж ашиглалтад орсон байна	Шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын тоогор илэрхийлнэ
1.14.	Арга хэмжээ: Олон улсын тээвэр, логистикийн төв байгуулна.	Логистик төв	Хувь	-	Судалгаа, шинжилгээний ажил хийгдээнэ	Барьж ашиглалтад оруулна	Үйл ажиллагаа жигдэрсэн байна	Шинээр байгуулагдах бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлнэ
1.15.	Арга хэмжээ: Ховд Улаангом чиглэлийн 163 км хатуу хүчилттай зам барина.	Хатуу хүчилттай авто замын хүчин чадал	км	ТЭЗҮ хийгдсэн	Ажлыг эхлүүлнэ	Замыг барина	Хатуу хүчилттай авто замын бүтээн байгуулалтын хэмжээг илэрхийлнэ.	Жилд нэг удаа
1.16.	Арга хэмжээ: Чиглэлийн 400 км хатуу хүчилттай зам барина.	Хатуу хүчилттай авто замын хүчин чадал	км	-	Судалгаа, шинжилгээний ажил хийгдэнэ	ТЭЗҮ хийгдэнэ	Зам барина	Хатуу хүчилттай авто замын бүтээн байгуулалтын

					Хэмжээг илэрхийлнэ.
1.17.	Арга хэмжээ: Аймгийн сумдтай хатуу хүчилттэй замаар бүрэн холбоно	Хатуу хүчилттэй авто замын хүчин чадал	11 сүм холбогдоно	12 сүм	13 сүм
1.18.	Арга хэмжээ: Баруун бүсийн санхүүгийн төв болно.	Арилжааны банкны салбарууд	Судалгааны ажил	Судалгааны ажил	Баруун бусийн эдийн засгийн чөлөөт бусийг тушиглэн санхүүгийн төв байгуулна
1.19.	Арга хэмжээ: хөдөө ак ахуйг эрчимжүүлэн хөгжүүлж, цогцолбор агро парк бий болгоно.	Баригдсан үйлдвэрүүд	Агро парк төслийн хэрэгжилт 10%	Тоо	Барьж байгуулан үйл ажиллагаагаа жилд нэг удаа
1.20.	Арга хэмжээ: Бус нутгийн татварын хөнгөлөлттэй бодлогыг хэрэгжүүлнэ.	Татварын хөнгөлөлт эдэлсэн аж ахуйн нэгж	Шилжин ирэх ААН-ийн тоо өснө	Шилжин ирэх ААН-ийн тоо өснө	Татварын хөнгөлөлт эдэгсэн аж ахуйн нэгжийн тоо болон мөнгөн дунгзэр илэрхийлнэ.
2.	Зорилт 2: Төр хувийн хэвшил, иргэний нийтийн байгууллагуудын хамтын төрийн ажиллагааг эрчимжүүлж, чанар, чанамж, хүчилгээний хуртээмжийг сайжруулах	Иргэдийн сэтгэл ханамж хувь	2022 оны сүүрь түвшин	Иргэдийн сэтгэл ханамжийн өсөлт	Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгээлийг хүлээснээ